

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2020 ОНЫ ТАВДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 05 дугаар сарын 28

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2020 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-ын гарцтай авто замын Баянхошуу, Бичигт, Хавирга боомт Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолын дагуу түр хаасан. Хоёр талын үйл ажиллагаатай, ачаа тээврийн зориулалттай Эрээнцав төмөр замын боомт, Газрын тосны тээвэрлэлтийн зөвшөөрөлтэй Баянхошуу боомт тус тус хуваарийн дагуу ажиллаж байна.

Тус хугацаанд 1 албан хаагч 2020 оны ээлжийн амралтаа биеэр эдэлж байна.

Нэг. Захиргаа, удирдлага

Байгууллагын даргын 2020 оны Б/125, Б/139 дүгээр тушаалаар мэргэжилтэн С.Баярцэцэг, Н.Ууган-Эрдэнэ нар тус тус томилогдсон.

Байгууллагын даргын 2020 оны 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг 7 хоног бүрийн Даваа гарагт Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст танилцуулан ажиллаж байна.

Байгууллагын удирдлагаас ирүүлсэн чиглэлийн дагуу ажилтан, албан хаагчдын өдөр тутмын ажлын цаг ашиглалтад хяналт тавин ажиллаж байна.

Мөн Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай Нийслэлийн Прокурорын газрын 2020 оны 1/15 дугаар мэдэгдлийг нийт албан хаагчдад танилцуулан, гарын үсгийн баталгааг авч төвд хүргүүлсэн.

Уулзалт, зөвлөгөөн, хамтын ажиллагаа: Аймгийн онцгой комиссын шуурхай хуралдаанд Бүсийн дарга 2 удаа оролцож хуралдаанаас гарч буй шийдвэрийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажиллах, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр Баянхошуу боомтын амьдрах байранд засвар хийн, бие бялдаржуулах өрөөг шинээр тохижуулан ашиглалтад оруулж, дасгалын 4 төрлийн төхөөрөмж, 20 орчим хэрэгслүүдийг байрлуулан суурилууллаа.

Мөн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 12 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулсан.

Сургалтад хамрагдсан талаар: Бүсийн газрын 2020 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бүсийн газрын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд байгууллагын албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдөр сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сургалтаар “Эрүүл зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг” сэдвээр аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн н.Сугар, “Цахим орчны аюулгүй байдал, кибер халдлагаас хамгаалах нь” сэдвээр аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтөр, “Стрессээс хэрхэн ангижрах тухай” сэдвээр Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын сургалт хариуцсан мэргэжилтэн Э.Мөнхтунгалаг, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-аар аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Л.Цагаан, “Эрчим хүчний хэмнэлт, цахим хэлбэрээр төлбөр хэрхэн төлөх тухай” “ДБЭХС” ТӨХК-ийн инженер н.Оюун, н.Байгаль, Төрийн болон албаны нууц, Төрийн албаны тухай хуулийн 37, 38, 39, 48 дугаар зүйлийн хүрээнд Захиргааны ахлах мэргэжилтэн Ц.Мөнхтуяа тус тус албан хаагчдад ойлголт, мэдээлэл өглөө.

Мөн захиргааны ахлах мэргэжилтэн сургалтад хамрагдсан 12 албан хаагчаас сургалтын талаарх санал авсан ба дараагийн сард зохион байгуулагдах сургалтын сэдвийн санал авч ажилласан.

Ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн-Урсгал Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулагдсан “Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх” сургалтад хамрагдан албан хаагчдын цалин, нэмэгдэл цалинг төрийн албан хаагчийн нэгдсэн программд оруулан ажиллаж байна.

Бичиг хэргийн эргэлтийн талаар: Ирсэн бичиг: Байгууллагын удирдлагаас 5, бусад байгууллагаас 9, нийт 14 албан бичиг ирсэн ба хугацаатай албан бичиг ирээгүй байна.

Явсан бичиг: Ажлын зохион байгуулалттай холбоотойгоор байгууллагын удирдах албан тушаалтанд явуулсан албан бичиг 2, бусад байгууллагад 15, нийт 17 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажиллалаа.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас цалинтай чөлөө хүссэн 2 өргөдөл хүлээн авч 3 хоногийн чөлөөг Бүсийн газрын даргын зөвшөөрлөөр тус тус олгосон.

Тус газарт ажилд орох хүсэлт гаргасан 6 иргэний өргөдлийг хүлээн авч 1 өргөдлийг төвд шилжүүлэн 5 өргөдлийг шийдвэрлэн ажиллалаа.

Санхүүгийн талаар: 2020 оны тавдугаар сард нийт 52,177,000.00 төгрөгийн санхүүжилтийг авснаас 37,982,880.53 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2020 оны тавдугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 286,561,100.00 төгрөгийн санхүүжилт, 193,431,308.69 төгрөгийн гүйцэтгэлтэй, 93,129,791.31 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны дөрөвдүгээр сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 731,600 төгрөг, хүү, торгуулийн орлогод 0.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын тавдугаар сарын тайлангаар нийт 25 албан хаагчдын 25,690,657.12 цалин, ногдол 5,900,737.77 төгрөг гарсныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтанд 2020 оны тавдугаар сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

Эд хөрөнгө, бараа материалын талаар: Бараа материалын тайланг сарын 30-ны өдрөөр тасалбар болгон Нийтийн аж ахуй, “ДБЭХС”, “Цахилгаан холбоо”, “Монгол шуудан”, “Мэдээлэл холбоо”, “НИК”, ХХК -тай тулгалтыг хийж тооцоо нийлсэн акт үйлдэн ажиллаа. Мөн Бүсийн газрын автомашины зам/км, шатахуун, бараа материалын тооцоог гарган ажилласан.

Бүсийн газрын албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд зориулж бичиг хэргийн 59 ширхэг хэрэгслийг 410,000 төгрөгөөр худалдан авалт хийж хангасан.

Хангалт үйлчилгээний чиглэлээр: Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу албан хаагч нарынхаа ая тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж Чийрэгжүүлэлтийн танхимтай болгосон засвар үйлчилгээ хийхэд нийт 50 нэр төрлийн 249 ширхэг материалыг 932400 төгрөгөнд худалдан авч гүйцэтгэсэн.

Шинээр ажилд томилогдсон мэргэжилтэн Н. Ууган-Эрдэнэд албаны хувцас, ялгах тэмдэг, 2018, 2019 онд гарсан хуулийн эмхэтгэл номуудаар ханган ажилласан.

Бүсийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 75-55 ДОА улсын дугаартай “НИССАН ПАТРОЛ” автомашин, 65-99 ДОА улсын дугаартай “ТОЁОТА ПРИУС”

автомашин, 74-39 ДОА улсын дугаартай “УАЗ ФУРГАН” автомашинуудыг “Монгол Даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын хязгааргүй даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалд хамрууллаа.

Ажлын болон амьдрах байрны өрөө тасалгаа, ариун цэврийг сахин мөрдүүлж, ариутгалын бодис болон цэвэрлэгээний бодисуудаар ханган ариутгал цэвэрлэгээг тогтмол хийлгэж байна.

Хэрлэн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар тус газарт Тоёота Ландкрузейр 200GXR маркийн автомашин худалдан авч хүлээлгэн өгсөн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хяналт тавьж ажилласан. Тус хугацаанд Сүхбаатар аймаг дахь төлөөллийн дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа хяналтын улсын байцаагч Б.Одмаа, А.Нэмэхбаяр нарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг бүртгэн авч, хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст танилцуулан тус программын эрхийг шилжүүлсэн.

Хилийн боомтуудын дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа 9 ширхэг компьютерт Eset endpoint security антивирусны программын лицензийг сунгаж 5 дугаар сарын антивирусны программын шинэчлэлтийг хийсэн.

Бүсийн газрын хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн талаарх судалгааг сүлжээний инженер Э.Ганзоригт танилцуулсан.

Бүсийн газарт мэргэжилтнээр томилогдсон Н.Ууган-Эрдэнэд Спарк программ, албаны email.gov.mn имэйл хаяг нээж хүлээлгэн өгсөн.

Төрийн албаны ил тод, нээлттэй байх, иргэдийг мэдээллээр хангах эрхийн дагуу www.immigration.gov.mn сайтын “Боомт орон нутаг” цэсэд 4 дүгээр сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 5 дугаар сарын төлөвлөгөөг шинэчилэн ажиллаад байна.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 4 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар гадаадын иргэн улсын хилээр нэвтрээгүй.

Тайлант хугацаанд бүсийн хэмжээнд виз олгогдоогүй болно.

Виз сунгалт: БНСВУ-ын 2 иргэний Монгол Улсад байх визийн хугацааг сунгасан.

Алдаатай визийн бүртгэл: байхгүй

Түр ирэгчийн бүртгэл -2, хасалт-2. БНСВУ-ын 2 иргэнд COVID-19 өвчний хорио цээрийн дэглэмийн хугацаанд түр ирэгчийн бүртгэлээр бүртгэж хасалт хийсэн.

Оршин суух зөвшөөрлийн хасалт: Хууль хяналтын байгууллагад шалгагдаж Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авагдсан тул “НГ” ангиллаар оршин суугаа БНСВУ-ын 2 иргэний оршин суух зөвшөөрлийг цуцалж хасалт хийсэн.

Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн ХУБ З.Өлзийбаяр Дорнод аймгийн 4-р багийн нутаг дэвсгэрт авто засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Ундрэнбэхжих” ХХК-ийн урилгаар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй БНСВУ-ын иргэн TRAN DINN TAN /1987.02.04-нд төрсөн, эрэгтэй N2184024 дугаарын паспорттай/, NGUEN DINH DUC /1990.03.10-нд төрсөн, эрэгтэй C1334291 дугаарын паспорттай/ нар нь Монгол улсын хууль, тогтоомж зөрчсөний улмаас холбогдох мэргэжлийн байгууллагуудад шалгагдаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас торгуулийн арга хэмжээ авагдсан байна.

БНСВУ-ын 2 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалтыг үндэслэн оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж, түр ирэгчээр бүртгэн авч, Чартер нислэгээр Монгол Улсаас гаргахыг сануулж хяналтын улсын байцаагчийн 12/034-01 дугаар “Албан шаардлага”-ыг хүргүүлж ажилласан.

Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр хил нэвтэрсэн зорчигч байхгүй

Хурууны хээ: байхгүй.

Хувийн урилга: Тайлант хугацаанд хувийн урилга олгоогүй.

Зөвлөгөө мэдээлэл: 1

- Ярилцлага хийсэн бүртгэл: 0

- Хилийн боомтуудад -

Баталгаа гаргасан: Байхгүй.

Сүлжээний хяналт: Байхгүй.

Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Тус газар нь тавдугаар сарын тайлангийн хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй.

2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Сүхбаатар аймгийн Прокурорын газраас ирүүлсэн 2030000088 дугаартай зөрчлийн хэрэгт холбогдох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн БАОYINDULENG /Баяндүүлэн,1981.09.12-нд төрсөн, эрэгтэй, EF3822492 дугаарын паспорттай, /-тай холбоотой зөрчлийн хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийж дуусаад Сүхбаатар аймгийн Прокурорын газарт хяналтанд хүргүүлээд байна.

Хяналт, эргүүлийн үүрэг гүйцэтгэх явцад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн FU GUOLIN /1986 оны 10 дугаар сарын 02-ны өдөр төрсөн, эрэгтэй, E03905075 дугаарын паспорттай/-нь Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн зөрчлийг илрүүлсэн.

Дээрхи иргэн нь Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №2019/ШЦТ/311 тогтоолоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн FU GUOLIN /1986 оны 10 дугаар сарын 02-ны өдөр төрсөн, эрэгтэй, E03905075 дугаарын паспорттай/ -г Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх барааны жагсаалтанд орсон саарал чонын хоншоор 1 ширхэг, чонын шагай 64 ширхэгийг нууж Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэх гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцогдож, 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1.000.000 /нэг сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгүүлсэн байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн FU GUOLIN /1986 оны 10 дугаар сарын 02-ны өдөр төрсөн, эрэгтэй, E03905075 дугаарын паспорттай/-ны талаар Хяналт шалгалтын газрын даргад илтгэх хуудсаар танилцуулж, Монгол Улсаас албадан гаргах дүгнэлтийг хүргүүлсэн. Хил нээхээр Монгол Улсаас албадан гаргах ажлыг зохион байгуулахаар чиглэл авсан.

ТАНИЛЦСАН.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТ, ОРОН
НУТГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТСҮХ

ХЯНАСАН.
ДАРГА

Б.ТАМИР

ТАЙЛАН БИЧСЭН.
ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Ц.МӨНХТУЯА